



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ДОА-2021/75/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын

менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.mn

Гэрээт аудитор: З.Шинэхүү

Утас: 70584204 Цахим хаяг: Shinekhuuz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	10
3.4. Материаллаг байдал .....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа.....	
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	12
Аудитын зөвлөмж.....	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	12

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 235

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХЭРЛЭН СУМЫН 5 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Т.ТОДГЭРЭЛ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020149

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>36,554,565.66</b>	<b>39,843,825.66</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	36,554,565.66	39,843,825.66
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	00.00	200,000.00
35130	Эм боох материал	00.00	200,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	36,554,565.66	39,643,825.66
35410	Бичиг хэргийн материал	881,450.00	552,200.00
35420	Аж ахуйн материал	26,529,368.66	29,236,278.66
35470	Бусад хангамжийн материал	9,143,747.00	9,855,347.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,212,704,037.94</b>	<b>1,201,322,899.04</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,212,704,037.94	1,201,322,899.04
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,032,035,537.94	1,021,042,899.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,017,348,962.25	1,017,348,962.25
39202	Хуримтлагдсан элэгдэл	-17,233,949.04	-36,169,224.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,401,887.50	20,447,522.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,176,646.99	-11,268,887.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,350,750.00	41,967,365.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,230,239.36	-35,993,814.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,977,757.00	31,127,757.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,402,983.42	-6,416,780.58
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	180,668,500.00	180,280,000.00
39301	Програм хангамж	1,158,500.00	1,158,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-1,158,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	180,280,000.00	180,280,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,249,258,603.60</b>	<b>1,241,166,724.70</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,249,258,603.60</b>	<b>1,241,166,724.70</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,249,258,603.60	1,241,166,724.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	184,855,297.56	184,855,297.56
51101	Өмч: - төрийн	184,855,297.56	184,855,297.56
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	238,768,531.12	230,676,652.22
51210	Өмнөх үеийн үр дүн	238,768,531.12	238,768,531.12
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-8,091,878.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	825,634,774.92	825,634,774.92
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,249,258,603.60</b>	<b>1,241,166,724.70</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>427,642,657.00</b>	<b>342,214,650.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>121,885,857.00</b>	<b>15,437,250.00</b>
121	Хөрөнгийн орлого	121,885,857.00	15,437,250.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	121,885,857.00	15,437,250.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>24,245,500.00</b>	<b>19,838,900.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	281,511,300.00	306,938,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	445,500.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	23,800,000.00	18,838,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,800,000.00	18,838,900.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>329,168,899.67</b>	<b>350,306,528.90</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>329,168,899.67</b>	<b>350,306,528.90</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>325,463,212.51</b>	<b>343,199,689.52</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,935,791.00	241,955,665.00
210101	Үндсэн цалин	184,659,479.00	187,742,967.51
210102	Нэмэгдэл	6,794,589.00	28,828,993.49
210104	Урамшуулал	15,481,723.00	25,383,704.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,815,108.84	30,457,746.62
210201	Тэтгэврийн даатгал	17,536,808.84	23,366,157.62
210202	Тэтгэмжийн даатгал	2,069,600.00	535,810.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,655,700.00	1,691,055.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413,900.00	422,938.00
210205	Эрүүд мэндийн даатгал	4,139,100.00	4,441,786.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,069,613.00	16,295,003.00
210301	Гэрэл, цахилгаан	2,912,803.00	1,726,037.00
210302	Түлш, халаалт	10,814,356.00	10,945,922.00
210303	Цэвэр, бохир ус	5,342,454.00	3,623,044.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,372,450.00	2,822,160.00
210401	Бичиг хэрэг	312,450.00	374,950.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000.00	188,300.00
210404	Ном, хэвлэл	00.00	64,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	113,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	1,581,910.00
2105	Нормативт зардал	45,728,450.00	20,913,926.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,000.00	86,600.00
210502	Хоол, хүнс	45,198,450.00	20,819,046.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	8,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	2,540,000.00
210604	Урсгал засвар	1,300,000.00	2,540,000.00
2107	Томилголт, зочны зардал	147,200.00	100,400.00
210702	Дотоод албан томилголт	147,200.00	100,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	230,000.00	472,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,000.00	232,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,864,599.67	27,642,388.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	250,000.00
210902	Хингэл үйлдвэрлэлийн дадлага хийх	176,000.00	199,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,288,599.67	27,193,388.90
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,705,687.16</b>	<b>7,106,839.38</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	113,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	113,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,505,687.16	6,993,839.38
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,505,687.16	6,993,839.38
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>98,473,757.33</b>	<b>-8,091,878.90</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>98,473,757.33</b>	<b>-8,091,878.90</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>305,756,800.00</b>	<b>326,777,400.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>305,756,800.00</b>	<b>326,777,400.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	281,511,300.00	306,938,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>445,500.00</b>	<b>1,000,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>23,800,000.00</b>	<b>18,838,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	23,800,000.00	18,838,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>305,756,800.00</b>	<b>326,777,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>305,756,800.00</b>	<b>326,777,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>302,051,112.84</b>	<b>319,670,560.62</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>206,953,700.00</b>	<b>241,955,665.00</b>
210101	Үндсэн цалин	184,677,387.00	187,742,967.51
210102	Нэмэгдэл	6,794,589.00	28,828,993.49
210104	Урамшуулал	15,481,724.00	25,383,704.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>25,797,199.84</b>	<b>30,457,746.62</b>
210201	Тэтгэврийн даатгал	17,518,899.84	21,784,974.62
210202	Тэтгэмжийн даатгал	2,069,600.00	2,113,993.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,655,700.00	1,691,055.00
210204	Ажилгүйдлийн даатгал	413,900.00	422,938.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,139,100.00	4,444,786.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>19,069,613.00</b>	<b>16,295,003.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,912,803.00	1,726,037.00
210302	Түлш, халаалт	10,814,356.00	10,945,922.00
210303	Цэвэр, бохир ус	5,342,454.00	3,623,044.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,768,450.00</b>	<b>3,761,400.00</b>
210401	Бичиг хэрэг	458,450.00	244,700.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000.00	188,300.00
210404	Ном, хэвлэл	250,000.00	150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	613,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	2,064,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>45,728,450.00</b>	<b>22,159,646.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,000.00	286,600.00
210502	Хоол, хүнс	45,198,450.00	20,819,046.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	1,054,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,300,000.00</b>	<b>2,540,000.00</b>
210604	Урсгал засвар	1,300,000.00	2,540,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>147,200.00</b>	<b>100,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	147,200.00	100,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>486,500.00</b>	<b>822,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	306,500.00	582,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	240,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>800,000.00</b>	<b>1,578,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	1,328,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,705,687.16</b>	<b>7,106,839.38</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>200,000.00</b>	<b>113,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	113,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>3,505,687.16</b>	<b>6,993,839.38</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,505,687.16	6,993,839.38

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00	00.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,855,297.56	825,634,774.92	238,768,531.12	00.00	1,249,258,603.60
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,855,297.56	825,634,774.92	238,768,531.12	00.00	1,249,258,603.60
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	184,855,297.56	825,634,774.92	238,768,531.12	00.00	1,249,258,603.60
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	-8,091,878.90	00.00	-8,091,878.90
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	184,855,297.56	825,634,774.92	230,676,652.22	00.00	1,241,166,724.70

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	182,015,400.00	168,462,468.00	328,934,000.00	318,783,560.62
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	182,015,400.00	168,462,468.00	328,934,000.00	318,783,560.62
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	181,815,400.00	168,262,468.00	328,821,000.00	318,670,560.62
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	119,458,400.00	119,140,316.00	241,979,200.00	241,955,665.00
210101	Үндсэн цалин	103,622,000.00	109,704,174.00	189,437,400.00	187,742,967.51
210102	Нэмэгдэл	4,230,400.00	1,554,725.00	30,172,500.00	28,828,993.49
210104	Урамшуулал	11,606,000.00	7,881,417.00	22,369,300.00	25,383,704.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	14,932,000.00	13,212,282.00	30,247,600.00	30,457,746.62
210201	Тэтгэврийн даатгал	10,153,900.00	8,709,775.00	20,568,400.00	21,784,974.62
210202	Тэтгэмжийн даатгал	1,194,600.00	1,129,055.00	2,419,800.00	2,113,993.00
210203	ҮОМШО-ний даатгал	955,700.00	903,224.00	1,935,600.00	1,691,055.00
210204	Ажилгүйдлийн даатгал	238,600.00	224,312.00	484,200.00	422,938.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,389,200.00	2,245,916.00	4,839,600.00	4,444,786.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,600,000.00	9,391,020.00	16,298,900.00	16,295,003.00
210301	Гэрэл, цахилгаан	2,300,000.00	1,580,438.00	1,728,100.00	1,726,037.00
210302	Түлш, халаалт	7,400,000.00	5,873,367.00	10,245,900.00	10,945,922.00
210303	Цэвэр, бохир ус	2,900,000.00	1,937,215.00	4,324,900.00	3,623,044.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,100,000.00	814,450.00	3,261,400.00	2,761,400.00
210401	Бичиг хэрэг	150,000.00	144,450.00	244,700.00	244,700.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00	200,000.00	562,800.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	160,000.00	120,000.00	125,500.00	188,300.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	00.00	150,600.00	150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	50,000.00	613,000.00	613,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	300,000.00	1,564,800.00	1,064,800.00
2105	<b>Нормативт зардал</b>	31,715,000.00	24,674,400.00	31,992,800.00	22,159,646.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,000.00	30,000.00	286,600.00	286,600.00
210502	Хоол, хүнс	31,185,000.00	24,644,400.00	30,652,000.00	20,819,046.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	00.00	1,054,200.00	1,054,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	800,000.00	00.00	2,540,000.00	2,540,000.00
210604	Урсгал засвар	800,000.00	00.00	2,540,000.00	2,540,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	150,000.00	00.00	100,400.00	100,400.00
210702	Дотоод албан томилолт	00.00	00.00	100,400.00	100,400.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	250,000.00	230,000.00	822,400.00	822,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,000.00	50,000.00	582,400.00	582,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00	240,000.00	240,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	800,000.00	800,000.00	1,578,300.00	1,578,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	400,000.00	400,000.00	250,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	400,000.00	1,328,300.00	1,328,300.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	200,000.00	200,000.00	113,000.00	113,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	200,000.00	200,000.00	113,000.00	113,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00	113,000.00	113,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	182,015,400.00	182,015,400.00	328,934,000.00	318,783,560.62
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	182,015,400.00	182,015,400.00	328,934,000.00	318,783,560.62
131001	Улсын төсвөөс санхүүжих	182,015,400.00	182,015,400.00	328,934,000.00	318,783,560.62
62	<b>АЖИЛЛАГАСДЫН ТОО</b>	00.00	00.00	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	09.00	09.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1000000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)		

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч Т.Тодгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 09-нөөс 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор З.Шинэхүү хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Хүүхдийг хүмүүнлэг, хамтач, үндэсний өв уламжлал ёс заншлаас тасралтгүй суралцагч, аливаа үйл ажиллагаанд бие даан оролцох, хөдөлмөрт хамтран суралцах чадварыг төлөвшүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй болно.

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 болон 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 329,168.9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 6,583.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 350,306.5 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 7,006.1 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,091.8 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө болон засгийн газрын оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага		-	
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	36,554.5	39,843.8	3,289.3
Үндсэн хөрөнгө	1,212,704.1	1,201,322.9	(11,381.2)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,249,258.6</b>	<b>1,241,166.7</b>	<b>(8,091.9)</b>
Өр төлбөр		-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,249,258.6	1,241,166.7	(8,091.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,249,258.6</b>	<b>1,241,166.7</b>	<b>(8,091.9)</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 39,843.8 мянган төгрөг болж 3,289.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант жилийн бараа материалын худалдан авалт 29,123.1 мянган төгрөг, 25,833.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 1,201,322.9 мянган төгрөг болж 11,381.2 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалт 375.0 мянга, хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй 15,437.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант үеийн элэгдлийн зардал 27,193.5 мянган төгрөг байснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,241,166.7 мянган төгрөг болж 8,091.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хэрлэн сумын 5 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 85,428.0 мянган төгрөгөөр буюу 19.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь санхүүжилт 85,428.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 21,137.6 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 16.9 хувь, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 24.0 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 5.4 хувиар тус тус өссөнөөс шалтгаалсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 408,352.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 408,352.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 79,418.6 мянган төгрөгөөр бууруулж 328,934.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан санхүүжүүлэхээр 328,934.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр нутгийн төсвөөс нийт 328,934.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 318,783.5 мянган төгрөгийг зарцуулж 6,993.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл нь 318,783.5 мянган төгрөг буюу 96.9 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 3.8 төгрөг, тэтгэмжийн зардлыг 305.8 төгрөг, норматив зардал 9,833.1 мянган төгрөгөөр тус, тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс 147 мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлэж байршуулсан байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж, бие даасан дүгнэлт гараагүй бөгөөд зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусдаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил гараагүй болно.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

